



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/273

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жил болгон зарлах тухай” 2018 оны 09/04 дүгээр тогтоол, “Аймгийн 2019 оны төсөв батлах тухай” 09/10 дугаар тогтоолын 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зорилтот жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх, бүх нийтээр мод тарих ажлын нээлт, тарьц, суулгацын үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, сумдын ногоон байгууламж хариуцсан ажилтнуудыг сургах, сургалт, сурталчилгааны материал хэвлүүлэх, сумдад нийлүүлэх тарьц, суулгац худалдан авах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 30512000 (гучин сая таван зуун арван хоёр мянга) төгрөгийн зардлыг орон нутгийн төсөвт батлагдсан зорилтот жилийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100599

Аймгийн Засаг даргын 2019 оны 05
 дүгээр сарын 05-ны өдрийн 4273 дугаар
 захирамжийн хавсралт



Зардлын задаргаа

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тоо хэмжээ		1 бүрийн үнэ	Нийт үнэ
1	Мод тарих өдрийн нээлт, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах	1			2000000
2	Гарын авлага /жимс, жимсгэнэ/ Зөвлөмж	600ш		1500	900000
		1100ш		800	800000
3	Стикер	Жижиг	1000ш	450	450000
		Том	30ш	1 200	36000
		Хөлтэй	1ш	36000	36000
4	Сумдад нийлүүлэх тарьц, суулгац худалдан авах	Улиас	1260ш	2500	24750000
		Хайлаас	4200ш	1500	
		Шар хуйас	8400ш	1500	
		Гоёл, чимэглэлийн мод	540ш	5000	
5	Ногоон байгууламж хариуцсан мэргэжилтэн, ажилтнуудыг сургах	ДТүлш	470л	2340	1100000
		Сургалтын төлбөр	22 хүн	20000	440000
Бүгд					30 512 000